**ЗООНОЗЫН МЭРГЭЖЛИЙН АЛБА,**
**ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 03 өдөр Дугаар А/43 Улаанбаатар хот

Тодотгосон төлөвлөгөө батлах тухай

"Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай" Эрүүл мэндийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинэ мутаци Омикрон хувилбар, цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор "Зоонозын мэргэжлийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны тодотгосон төлөвлөгөө"-г хавсралтаар батлалсугай.

2. Тодотгосон төлөвлөгөөний дагуу хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулан, төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэн, сахилга хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг Хариу арга хэмжээний багийн ахлагч (Ц.Энхбаяр, Д.Отгонбаяр, Д.Алтантогтох, Д.Ганболд, З.Ууганцэцэг) нарт үүрэг болгосугай.

3. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинэ мутаци Омикрон хувилбар, цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Зоонозын мэргэжлийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны хариу арга хэмжээний багуудын үйл ажиллагааны товч тайлан, мэдээллийг тогтмолжуулах, танилцуулга хийж ажиллан нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Менежер (Б. Амгаланбаяр)-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зоонозын мэргэжлийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежер (Б.Амгаланбаяр)-т үүрэг болгосугай.

ЗООНОЗЫН МЭРГЭЖЛИЙН АЛБА-ТОХИОЛДЛЫН
УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ
ДАРГА Н.ЦОГБАДРАХ

Зоонозын мэргэжлийн алба,Тохиолдлын удирдлагын
тогтолцооны даргын 2021 оны ..12... дугаар сарын
..03...-ны өдрийн ..А/...дугаар тушаалын хавсралт
А/73

# ЗООНОЗЫН МЭРГЭЖЛИЙН АЛБА, ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ТОДОТГОСОН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл | Гүйцэтгэх ажил үйлчилгээ | Хариуцах ТУТ-ны баг | Хариуцах албан тушаалтан | Хугацаа |
|---|---|---|---|---|---|
| | ***НЭГ. САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА*** | | | | |
| 1.1 | ЭМЯ-УОК-т ЗМА-ТУТ-ны зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар мэдээ мэдээллийг хүргэх | Үйл ажиллагааны уялдаа холбоог хангах уулзалт ярилцлага, хамтын ажиллагааны гэрээ | ТУТ-ны зохицуулагч | Н.Цогбадрах<br>Б.Амгаланбаяр | Тогтмол |
| 1.2 | ЗМА-ТУТ-ны мэргэжлийн багуудын мэдээллийг бэлтгэж, ТУТ хуралд танилцуулах | | ЗМА-ТУТ-ны багийн ахлагч нар | Д.Отгонбаяр<br>Ц.Энхбаяр<br>Д.Ганболд<br>Д.Алтантогтох<br>З.Ууганцэцэг | Тогтмол |
| 1.3 | Нийслэл, аймгийн эрүүл мэндийн газар, бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах, Орон нутгийн ЗӨСТ-үүдэд зөвлөмж хүргүүлэх | | ТУТ-ны менежер<br>Хариу арга хэмжээний баг | Б.Амгаланбаяр<br>Д.Отгонбаяр | Тогтмол |
| 1.4 | ЗМА-ТУТ-ний мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээгээр түгээх | | Эрсдэлийн харилцаа холбооны баг | Д.Алтантогтох<br>О.Даариймаа | Тогтмол |
| | ***ХОЁР.ШУУРХАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ*** | | | | |
| 2.1. | Sars-Cov-2-ын шинэ мутац Омикрон хувилбар, цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан шуурхай хариу арга хэмжээний багийг тухай бүр шинэчлэх | А. Шуурхай хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүнийг хуваарилах<br>Б. ЗМА-ТУТ-ны ерөнхий захирлын тушаалаар томилж батлуулах | Төлөвлөлт, хариу арга хэмжээний баг | Д.Отгонбаяр<br>Ц.Энхбаяр | Шаардлагатай тухай бүрт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2.2. | Цар тахлын нөхцөл байдал, Sars-Cov-2-ын шинэ мутац, омикрон хувилбартай холбоотойгоор бусад байгууллагатай хамтарсан эрсдэлийн үнэлгээ хийж төлөвлөгөөг тодотгон хэрэгжүүлэх. | *А. “Коронавируст халдвар, Sars-Cov-2-ын шинэ мутац, омикрон хувилбар, цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан цагийн байдлыг тодорхойлох эрсдэлийн үнэлгээг хийх* | ЗМА-ТУТ | Б.Амгаланбаяр<br>Ц.Энхбаяр | 12 дугаар сард |
| 2.3 | Хилийн нэвтрэх цэгийн тандалтыг эрчимжүүлэх, тусгаарлах үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, тухай бүр зөвлөмжөөр хангах | Цар тахлын нөхцөл байдал, Sars-Cov-2-ын шинэ мутац, омикрон хувилбартай холбоотой хилийн нэвтрэх цэг бүхий Аймгийн ЗӨСТ-ийг мэргэжил арга зүйгээр хангах, | Хариу арга хэмжээний баг | Д.Отгонбаяр | Тогтмол |
| 2.4 | Цар тахлын нөхцөл байдал, Sars-Cov-2-ын шинэ мутаци омикрон хувилбартай холбоотойгоор хариу арга хэмжээний бэлэн байдлыг шуурхай хангах, халдвар хамгаалал, био аюулгүй ажиллагаа, голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийн талаар мэргэжил арга зүйн удирдлагар хангах | *А. Нөхцөл байдалд нийцүүлэн шаардлагатай гарын авлага, санамж, зөвлөмжүүдийг шинэчлэх боловсруулан, хэвлүүлэн түгээх*<br>Б. Нийслэл, дүүргийн ЭМТ шуурхай хариу арга хэмжээний багуудад сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах<br>В. Аймаг, орон нутгийн ЭМГ-ын шуурхай хариу арга хэмжээний багуудад зайн сургалтыг үргэлжлүүлэн хийх | Хариу арга хэмжээний баг | Д.Отгонбаяр | Шаардлагатай тухай бүрт |
| 2.5. | Цар тахлын нөхцөлд тохируулан Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны удирдлага, Онцгой комисс, тусгаарлах байр, СӨХ-ООД, улсын онц чухал обьектуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх. | А. Халдвар хамгааллын дэглэмийг сайжруулах, урьдчилан сэргийлэх байнгын ариутгал халдваргүйтгэл хийх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх | Хариу арга хэмжээний баг | Д.Отгонбаяр | Тогтмол |
| 2.6. | Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Тусгай мэргэжлийн төвүүд, Нэгдсэн эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн багуудад | А. Дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн багуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслаж чадавхижуулах | Хариу арга хэмжээний баг | Д.Отгонбаяр | Тогтмол |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх давтан болон дадлагажуулах сургалтанд үргэлжлүүлэн хамруулах | Б. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа тусгай мэргэжлийн төвүүдийн халдваргүйжүүлэлтийн багуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслаж чадавхижуулах | | | |
| | | В.ЭМЯ-ны харьяа эмнэлгүүд, тусгай мэргэжлийн төвүүдийн халдваргүйжүүлэлтийн багуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслаж чадавхижуулах | | | |
| | | Г.Аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн багуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслаж чадавхижуулах | | | |
| | | Д. Нийслэлийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын халдваргүйжүүлэлтийн багуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслаж чадавхижуулах | | | |
| | | Е.Аймгийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын халдваргүйжүүлэлтийн багуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслаж чадавхижуулах | | | |
| | | Ё.Нийслэлийн томоохон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгжийн халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд зөвлөн туслах | | | |
| 2.7. | Лабораторийн үйл ажиллагаа | А. Суурин лабораторийн оношилгооны бэлэн байдлыг хангах | Шуурхай хариу арга хэмжээний баг | Д.Ганболд | Тогтмол |
| | | Б. Автолабораторийн оношилгооны бэлэн байдлыг хангах, | Шуурхай хариу арга хэмжээний баг | Д.Ганболд | Тогтмол |
| | | В. Оношлуур урвалж бодисын нөөцийн тооцоо гаргах, захиалга хийх | Шуурхай хариу арга хэмжээний баг | Д.Ганболд | Тогтмол |
| | | Г. Сорьц цуглуулах, шинжилгээг хийх | Шуурхай хариу арга хэмжээний баг | Д Ганболд | Тогтмол |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Д. Цар тахлын нөхцөл байдал, Sars-Cov-2-ын шинэ мутац, омикрон хувилбартай холбоотой зорчигчдыг шинжилгээнд хамруулах, тусгаарлах үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх. | Шуурхай хариу арга хэмжээний баг | Д.Ганболд | Тогтмол |
| | | ***ГУРАВ.ЭРСДЭЛИЙН ҮЕИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО*** | | | |
| 3.1 | Цар тахлын нөхцөл байдал, Sars-Cov-2-ын шинэ мутац, омикрон хувилбартай холбоотой цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллээр ЗМА-ТУТ–ны удирдлага, багуудыг хангах | А. Олон улсад хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл явдлын талаарх сайн туршлагыг судлах, байгууллагын болон бусад эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдэд түгээх | Эрсдэлийн харилцаа холбооны баг | Д.Алтантогтох | Тогтмол |
| 3.2 | Цар тахлын нөхцөл байдал, Sars-Cov-2-ын шинэ мутац, омикрон хувилбартай холбоотой ЗМА-ТУТ-ны хэрэгжүүлж буй үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчилах | А. Байгууллагын www.nczd.gov.mn цахим хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан ард иргэдийг тогтмол мэдээллээр хангах<br>Б. Урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах<br>В. Харьяа ЗӨСТ-үүдийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл түгээх<br>Г. ЗӨСҮТ-өөс зохион байгуулж буй арга хэмжээ, мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээх<br>Д. Цахим орчинд нийтлэгдэж буй мэдээллүүдэд дүн шинжилгээ хийж ард иргэдийг үнэн бодит мэдээллээр хангах | | | |
| 3.3 | Цар тахлын нөхцөл байдал, Sars-Cov-2-ын шинэ мутац, омикрон хувилбартай холбоотойгоор төвийн ажилчдыг халдвараас сэргийлэх, хяналтыг | А. Төвийн хэмжээнд эрсдлийн үнэлгээг тогтмол хийж, мэдээллээр тухай бүрт хангах<br>Б. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ЗМА-ТУТ-ны хуралд тогтмол танилцуулах | Чанарын алба, Дэглэмийн баг | У. Нармандах<br>Ц. Отгонцэцэг | Тогтмол |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | эрчимжүүлэх эрсдлийг бууруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулах | В. Коронавируст халдварын үед ажиллах шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдал, нөөцийн хангалтад эрсдэлийн үнэлгээ хийж танилцуулах. | Нөөц бэлэн байдал хангалтын баг | У.Нармандах<br>Ц.Саруул | Сар бүр |
| ***ДӨРӨВ. НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДАЛ*** | | | | | |
| 4. 1 | Хүний нөөцийн бэлэн байдал | А. Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүний болон шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулах үеийн хүний нөөцийн бэлэн байдлын судалгаа гаргах, хуваарилалт хийх, аюулгүй байдлыг хангах<br>Б. Шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдийн ажил, амралтын цагийн хуваарьт тухай бүр зохицуулалт хийх,эргэн мэдээллэх<br>В. Орон нутгийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн хүний нөөцийн бэлэн байдлын судалгааг гаргах, бэлэн байдлыг хангуулах | Хүний нөөцийн баг | Б.Отгоннавсо | |
| 4.2 | ЗМА-ТУТ-ын баг бүрэлдэхүүний аюулгүй ажиллах нөхцөлийг бүрэлдүүлэх | А. Ажлын байрны хэвийн үйл ажиллагааны бэлэн байдлыг тогтмол хангах<br>Б. Дуудлага түргэн тусламжийн болон явуулын лабораторийн автомашинуудын бэлэн байдлыг хангах<br>В. Шуурхай хариу арга хэмжээнд шаардлагатай эд зүйлс, бараа материал, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувцас хэрэгслээр хангах | Нөөцийн бэлэн байдал, хангалтын баг | З.Орхонсүрэн | Тогтмол |
| 4.3 | Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдал, нөөцийн бүрдүүлэлт хийх | А. Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөцийн хангалтийг бүрдүүлэх, зарцуулалтын мэдээллийг тогтмол гаргах<br>Б. Аймаг, нийслэлийн ЗӨСТ-ийн бэлэн байдлын нөөцийн судалгаа гаргах | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ***ТАВ. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ*** | | | | | |
| 5.1 | Санхүү, хөрөнгө оруулалтын багийн цар тахлын үед хэрэгжүүлэх үйл ажиллагаа | А. Шаардлагатай бэлтгэн нийлүүлэх бараа материал, хөрөнгө оруулалт олох, гэнэтийн шаардлагатай тохиолдолд санхүүгийн эх үүсвэрийг тасалдалгүй зохион байгуулах.<br>Б. Төсөвт тусгагдаагүй бусад зардлын /илүү цаг, тэтгэмж, хөрөнгө оруулалт гм/ тооцоог хийж дээд шатны байгууллагуудад танилцуулж шийдвэрлүүлэх | Санхүү Хөрөнгө Оруулалтын баг | З.Ууганцэцэг | Тогтмол |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТОДОТГОСОН:

ЗООНОЗЫН МЭРГЭЖЛИЙН АЛБА,ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАГ